



СҮХБААТАР ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН НЭГДҮГЭЭР ХЭЛТЭС

2017 оны 05 дүгээр сарын 12-ны өдөр

№ 10.

Улаанбаатар хот

МЭДЭГДЭЛ

_____ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

_____ ТАНАА

Сүүлийн жилүүдэд насанд хүрээгүй хүн гэмт хэрэг, зөрчилд холбогдох, эрх ашиг сонирхол нь олон хэлбэрээр зөрчигдөж, амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаагаараа хохирч байна.

Улсын хэмжээнд 2016 онд насанд хүрээгүй хүмүүсээс ахуйн хэрэглээний газ болон мансруулах төрлийн бодис /гутлын тос, шар цавуу, бензин, эм бэлдмэл/ хэрэглэсэн гэх дуудлага, мэдээлэл 30 бүртгэгдсэн, 2017 оны эхний 4 сарын байдлаар 16 бүртгэгдэж, 25 хүүхэд хохирсноос 2 хүүхэд нас барсан.

Ахуйн хэрэглээний газ, мансууруулах төрлийн бодис хэрэглэсэн хүмүүсийг насны байдлаар нь авч үзэхэд 14-17 насны 17, 18-26 насны 8, хүйсийн хувьд эмэгтэй 2, эрэгтэй 23, нийгмийн байдал нь оюутан 9, сурагч 16 байна.

Мөн "Цэнхэр халим" тоглоомын талаарх мэдээлэл фейсбүүк, социал сайтуудаар тархсантай холбогдуулан насанд хүрээгүй хүмүүс энэ төрлийн тоглоомонд орох, донтох, хамтран тоглосоноор даалгавар биелүүлж, амь нас алдах тохиолдол гарч байгаа тул дээрх гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд дараах ажлыг хийж хамтран ажиллана уу. Үүнд:

1. Оюутан, сурагчдад ахуйн хэрэглээний газ, мансууруулах төрлийн бодисын хор хөнөөл, цахим орчинд тархсан сөрөг үр дагавар бүхий тоглоомоос урьдчилан сэргийлэх чиглэлээр багш, сурган хүмүүжүүлэгч нарт сургалт зохион байгуулах

2. Багш, сурган хүмүүжүүлэгч нараас сургуулийн оюутан, сурагчдад хандан үнэн зөв мэдээлэл хүргэх, болзошгүй үр дагаврыг тайлбарлан ойлгуулах, өөрийгөө болон бусдыг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ухуулга, сурталчилгааны ажлыг зохион байгуулах

3. Дээр дурдсан гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй оюутан, сурагчдын судалгааг гарган, судалгаанд авагдсан хүмүүсийн эцэг, эх, асран хамгаалагч нартай уулзаж хүүхдэд тавих хяналтыг сайжруулах, хууль хяналтын байгууллагаас зөвлөгөө өгүүлэн, хамтран ажиллах


4. Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэх

Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу тодорхой ажил зохион байгуулан 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хариу мэдэгдэнэ үү.

Шаардлагатай тохиолдолд 102, 70120137, 99079762 дугаарын утсанд хандана уу.

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

С.БУЯНЖАРГАЛ



**ИХ, ДЭЭД БОЛОН КОЛЛЕЖ, МЭРГЭЖИЛ, СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ,
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ДУНД СУРГУУЛИЙН УДИРДЛАГА, ХАМТ ОЛОНД**

2017.05.08

Улаанбаатар хот

Зөвлөмж хүргүүлэх тухай

Улсын хэмжээнд 2016-2017 оны хичээлийн жилд 94 их, дээд сургууль болон коллеж, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийг 35000 орчим оюутан, ерөнхий боловсролын 778 дунд сургуулийг 37581 сурагч төгсөж байна.

Иймд оюутан, сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах зөвлөмж хүргүүлж байна. Үүнд:

1.Төгсөлтийн арга хэмжээг зохион байгуулахдаа Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиуд болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн "Эрдмийн баяр тэмдэглэх тухай" А/147 дугаар тушаал, Нийслэлийн Боловсролын газрын 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн "Ерөнхий боловсролын сургуулиудын эрдмийн баяр зохион байгуулах ажлын зөвлөмж"-ийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

2.Ялангуяа сургууль бүр дотооддоо гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, төгсөлтийн арга хэмжээний үеэр хяналтыг сайжруулж, багш нарыг хариуцлагатай жижүүрээр томилон ажиллуулах хуваарийг гарган, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах.

3. Төгсөлтийн арга хэмжээний үеэр гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр оюутан, сурагчдын дунд яриа таниулга хийж, зохион явуулж байгаа ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах.

4.Харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтэс, сум, хороодын хэсгийн төлөөлөгч, байцаагч нарт "Эрдмийн баяр"-ыг тэмдэглэх хугацаа, зохион байгуулах газрын мэдээллийг хүргүүлж, энэ үйл ажиллагаанд эцэг эхчүүдийг татан оролцуулах, тэдний дэмжлэгийг авч хамтран ажиллах.

5.Арга хэмжээг хөдөө хээр, амралт зуслан, жуулчны бааз, зочид буудал, баар, цэнгээний газруудад зохион байгуулахгүй байх, архи, согтууруулах ундаа хэрэглүүлэхгүй байх, эцэг эх, асран хамгаалагч, сурагчдад хүндрэл учруулахгүйгээр зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.

6.Төгсөлтийн баярыг "Эрдмийн баяр" болгон тэмдэглэх ажлын хүрээнд оюутан, сурагчдын дунд сурч мэдсэн, хийж бүтээснээ тайлагнах, төгсөгчдийг урамшуулах, тэргүүний сурагчдыг алдаршуулах тайлант өдөрлөг, боловсролын гэрчилгээ гардуулах хүндэтгэлийн арга хэмжээ болгон зохион байгуулах.

7.Төгсөгчдийн дунд "Хонхны баяр"-ыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж байгаа зарим сургуулийн "Сайн туршлага"-ыг түгээн дэлгэрүүлэх, төгсөгчдийн нэрэмжит мод тарих, ногоон орчин бий болгох, хийж бүтээсэн ажлаа олон нийтэд таниулж, бусдадаа бүтээлч, зөв үлгэр дуурайл үзүүлэх чиглэлээр зохион байгуулах.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ
ГАЗАР

МОНГОЛЫН ОЮУТНЫ
ХОЛБОО

МОНГОЛЫН СУРАГЧДЫН
ХОЛБОО